



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/96/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: [bayanjargalg@audit.gov.mn](mailto:bayanjargalg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	18
4.1 Ерөнхий зүйл .....	18
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	19
5.1 Төлбөрийн акт.....	20
5.2 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ .....	22
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл .....	22
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл .....	23
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	23

#### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ГҮТББ	Гишүүддээ үйлчилдэг төрийн бус байгууллага

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум  
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/67  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Г.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна.

Төв аймгийн Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 01 тогтоолоор сумын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө баталсны дагуу ойн арга хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотойгоор гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг нэвтрүүлэхээр “Ухаалаг засаглал” Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай гэрээ хийж 3,000.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж шинэчлэхээр Си Ти Эм хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээний дагуу 3,500.0 мянган төгрөг төлж, программ хангамжийн дансанд авч тайлагнасан байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн дараах асуудлууд байна. Үүнд:

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлж, дэд бүтцийн болон нийгмийн салбарт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, сумын Засаг даргын 2018 оны А/603 дугаар захирамжаар 4 га газрын асуудлыг шийдвэрлэсэн “Заамар парк” цэцэрлэгт хүрээлэнд ёслол хүндэтгэлийн өргөө, сагсан бөмбөг, элсний волейбол, хөл бөмбөг, граунд гольфийн талбай, морин тойруулгын тоглоом, кофе шопын барилга, автомашины зогсоол бүхий цогцолбор байгуулан ашиглалтад оруулж, Заамар сумын Засаг даргын Тамгын газрын хөрөнгөнд бүртгэсэн байна.

Сумын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын төвдөө 3 км хатуу хучилттай авто замыг нийгмийн хариуцлагын гэрээгээр гүйцэтгүүлсэн байна.

Монголын баялаг 330 төслийн баг хамт олонтой хамтран ажиллах гэрээ байгуулан, 3 бүлэгтэй 30 минутын баримтат кино бүтээсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>165,064,732.00</b>	<b>347,769,718.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>10,830,357.00</b>	<b>63,501,674.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>10,830,357.00</b>	<b>63,501,674.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	10,830,357.00	63,501,674.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>154,234,375.00</b>	<b>284,268,044.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>154,234,375.00</b>	<b>264,268,044.00</b>
35410	Бичиг хэргийн материал	839,320.00	686,000.00
35420	Аж ахуйн материал	36,375,810.00	133,180,199.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0	1,851,950.00
35440	Түлш, шатах тослох материал	6,881,650.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	110,137,595.00	128,549,895.00
35600	Мал амьтад	0	20,000,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,730,776,056.93</b>	<b>7,552,515,533.15</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>3,730,776,056.93</b>	<b>7,552,515,533.15</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,999,096,256.93</b>	<b>6,814,335,733.15</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,440,431,805.72	5,031,760,091.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	-621,056,125.90	-728,280,263.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	706,051,320.00	807,851,320.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-334,287,517.50	-381,652,570.71
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	484,205,244.50	524,329,378.70
39206	Хуримтлагдсан элэгдэл	-292,334,322.52	-337,022,205.97
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	135,210,046.00	133,734,016.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-94,990,892.16	-101,612,716.87
39209	Зам, гүүрийн байгууламж	94,472,056.00	94,472,056.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-33,108,769.32	-46,375,947.48
39214	Бусад үндсэн хөрөнгө	957,436,924.00	2,315,634,167.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-442,933,511.89	-498,501,591.53
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>731,679,800.00</b>	<b>738,179,800.00</b>
39301	Програм хангамж	0	6,500,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	731,679,800.00	731,679,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,895,840,788.93</b>	<b>7,900,285,251.15</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>60,360.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>60,360.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>60,360.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>60,360.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	60,360.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,895,840,788.93</b>	<b>7,900,224,891.15</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,895,840,788.93</b>	<b>7,900,224,891.15</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,237,518,913.32	2,237,518,913.32
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	2,237,518,913.32	2,237,518,913.32
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,251,157,678.21</b>	<b>5,255,541,780.43</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,303,887,407.84	1,251,157,678.21
51220	Тайлант үеийн үр дүн	-52,729,729.63	4,004,384,102.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,164,197.40	407,164,197.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,895,840,788.93</b>	<b>7,900,285,251.15</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>337,378,163.00</b>	<b>6,673,454,806.00</b>
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	3,630,698,103.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	3,630,698,103.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>337,378,163.00</b>	<b>3,042,756,703.00</b>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	9,605,463.00	384,024,003.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,264,086.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,112,760.00	309,100,803.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,228,617.00	74,923,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>327,772,700.00</b>	<b>2,658,732,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	327,772,700.00	2,658,732,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>404,936,925.84</b>	<b>2,669,070,703.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>404,936,925.84</b>	<b>1,714,033,271.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>391,545,425.84</b>	<b>1,191,004,430.97</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>108,172,269.28</b>	<b>453,208,425.85</b>
210101	Үндсэн цалин	88,891,256.12	340,404,493.29
210102	Нэмэгдэл	14,452,756.76	106,019,521.51
210104	Урамшуулал	4,828,256.40	6,784,411.05
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>13,917,322.70</b>	<b>57,760,656.50</b>
210201	Тэтгэврийн даатгал	11,882,657.20	49,300,152.89
210202	Тэтгэмжийн даатгал	527,764.45	2,177,917.83
210203	ҮОМШӨ-ний даатгал	402,051.53	1,760,703.56
210204	Ажилгүйдлийн даатгал	99,720.70	463,496.10
210205	Эрүүл мэндийн даатгал	1,005,128.82	4,058,386.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,182,130.00</b>	<b>79,396,752.84</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,173,312.00	23,679,953.98
210302	Түлш, халаалт	20,008,818.00	53,137,628.86
210303	Цэвэр, бохир ус	00.00	2,579,170.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>37,263,116.00</b>	<b>104,488,333.00</b>
210401	Бичиг хэрэг	2,002,200.00	3,906,715.00
210402	Тээвэр, шатахуун	18,555,886.00	75,230,018.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,850,680.00	4,851,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,093,000.00	20,500,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,194,500.00	00.00
210408	Бараа материал акталсны зардал	3,566,850.00	
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>5,347,500.00</b>	<b>1,800,000.00</b>
210604	Урсгал засвар	5,347,500.00	1,800,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,348,000.00</b>	<b>9,052,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,348,000.00	9,052,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>27,158,790.64</b>	<b>4,039,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	26,070,704.64	3,952,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,088,086.00	87,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>171,156,297.22</b>	<b>481,259,262.78</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,374,760.00	139,736,570.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,781,537.22	341,522,692.78
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>13,391,500.00</b>	<b>523,028,840.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>13,391,500.00</b>	<b>20,732,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,675,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	716,000.00	20,732,500.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>502,296,340.81</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	502,296,340.81

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>955,037,432.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	955,037,432.00
220001	Барилга байгууламж	00.00	683,420,714.00
221001	Их засвар	00.00	204,519,012.00
222001	Тоног төхөөрөмж	00.00	1,028,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	66,069,706.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-67,558,762.84</b>	<b>4,004,384,102.22</b>
145	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	00.00	00.00
225	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	00.00
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	00.00
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-67,558,762.84</b>	<b>4,004,384,102.22</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>			
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,586,682,903.00</b>	<b>3,054,030,943.00</b>
11	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>443,883.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	443,883.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	443,883.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	443,883.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,586,682,903.00</b>	<b>3,053,587,060.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27,543,103.00	394,854,360.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,264,086.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,272,760.00	309,100,803.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,006,257.00	85,753,557.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	1,559,139,800.00	2,658,732,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,559,139,800.00	2,658,732,700.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>599,150,678.06</b>	<b>1,451,381,769.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>599,150,678.06</b>	<b>1,451,381,769.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>583,695,932.06</b>	<b>895,868,701.19</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	224,946,743.10	453,652,308.85
210101	Үндсэн цалин	181,831,063.40	335,353,414.06
210102	Нэмэгдэл	31,146,264.65	100,562,003.60
210104	Урамшуулал	11,969,415.05	17,736,891.19
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,806,310.43	57,760,656.50
210201	Тэтгэврийн даатгал	19,742,717.76	39,574,939.68
210202	Тэтгэмжийн даатгал	2,316,496.21	4,627,847.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,799,436.97	3,706,592.40
210204	Ажилгүйдлийн даатгал	449,067.06	925,589.40
210205	Эрүүл мэндийн даатгал	4,498,592.43	8,925,688.02
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	56,635,265.71	79,396,752.84
210301	Гэрэл, цахилгаан	11,164,033.71	13,384,906.22
210302	Түлш, халаалт	43,071,232.00	63,432,676.62
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	2,579,170.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	96,221,340.00	89,178,595.00
210401	Бичиг хэрэг	6,384,374.00	3,305,475.00
210402	Тээвэр, шатахуун	65,172,286.00	60,461,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,164,680.00	4,911,520.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,500,000.00	20,500,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	28,392,900.00	22,300,000.00
210604	Урсгал засвар	28,392,900.00	22,300,000.00

<b>2107</b>	<b>Томиллолт, зочны зардал</b>	9,436,700.00	9,052,000.00
210702	Дотоод албан томиллолт	9,436,700.00	9,052,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	54,053,912.82	18,898,650.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	52,605,826.82	18,811,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,088,086.00	87,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	85,202,760.00	165,629,738.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	85,202,760.00	165,629,738.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,454,746.00</b>	<b>555,513,067.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>15,454,746.00</b>	<b>18,939,640.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,675,500.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,779,246.00	18,939,640.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	536,573,427.81
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	536,573,427.81
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>987,532,224.94</b>	<b>1,602,649,174.00</b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>281,303,337.00</b>	<b>1,602,649,174.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>281,303,337.00</b>	<b>1,602,649,174.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>281,303,337.00</b>	<b>1,602,649,174.00</b>
220001	Барилга байгууламж	99,300,000.00	1,236,509,083.00
221001	Их засвар	34,985,200.00	213,436,442.00
222001	Тоног төхөөрөмж	43,216,000.00	14,871,000.00
223001	Бусад хөрөнгө	103,802,137.00	137,832,649.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-281,303,337.00</b>	<b>-1,602,649,174.00</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>706,228,887.94</b>	<b>00.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,237,518,913.32</b>	<b>407,164,197.40</b>	<b>1,303,887,407.84</b>	<b>3,948,570,518.56</b>
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
<b>3</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,237,518,913.32</b>	<b>407,164,197.40</b>	<b>1,303,887,407.84</b>	<b>3,948,570,518.56</b>
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-52,729,729.63	-52,729,729.63
<b>10</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,237,518,913.32</b>	<b>407,164,197.40</b>	<b>1,251,157,678.21</b>	<b>3,895,840,788.93</b>
<b>11</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,237,518,913.32</b>	<b>407,164,197.40</b>	<b>1,251,157,678.21</b>	<b>3,895,840,788.93</b>
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
<b>13</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,237,518,913.32</b>	<b>407,164,197.40</b>	<b>1,251,157,678.21</b>	<b>3,895,840,788.93</b>
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	4,004,384,102.22	4,004,384,102.22
<b>20</b>	<b>2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>2,237,518,913.32</b>	<b>407,164,197.40</b>	<b>5,255,541,780.43</b>	<b>7,900,224,891.15</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,658,732,800.00	2,161,313,116.95
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	821,237,500.00	787,888,529.95
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	802,237,500.00	768,948,889.95
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	429,184,300.00	417,668,825.08
210101	Үндсэн цалин	370,923,300.00	320,315,791.21
210102	Нэмэгдэл	58,261,000.00	79,616,142.68
210104	Урамшуулал	00.00	17,736,891.19
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,648,000.00	53,318,194.03
210201	Тэтгэврийн даатгал	36,480,600.00	36,480,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,291,900.00	4,291,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,433,500.00	3,433,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	858,400.00	858,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,583,600.00	8,253,794.03
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	92,086,700.00	79,396,752.84
210301	Гэрэл, цахилгаан	15,393,700.00	13,384,906.22
210302	Түлш, халаалт	72,193,000.00	63,432,676.62
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	2,579,170.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	88,181,200.00	88,055,720.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,182,600.00
210402	Тээвэр, шатахуун	60,461,600.00	60,461,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,219,600.00	4,911,520.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	20,500,000.00	20,500,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,300,000.00	2,300,000.00
210604	Урсгал засвар	2,300,000.00	2,300,000.00
2107	<b>Томилголт, зочны зардал</b>	15,321,000.00	9,052,000.00
210702	Дотоод албан томилголт	15,321,000.00	9,052,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,956,300.00	9,390,950.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,500,000.00	9,303,950.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	360,000.00	00.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,096,300.00	87,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	110,560,000.00	109,766,448.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	110,560,000.00	109,766,448.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	19,000,000.00	18,939,640.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	19,000,000.00	18,939,640.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	19,000,000.00	18,939,640.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,837,495,300.00</b>	<b>1,373,424,587.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,837,495,300.00</b>	<b>1,373,424,587.00</b>
220001	Барилга байгууламж	1,057,182,300.00	1,036,509,083.00
221001	Их засвар	265,147,800.00	213,436,442.00
222001	Тоног төхөөрөмж	15,000,000.00	14,871,000.00
223001	Бусад хөрөнгө	500,165,200.00	108,608,062.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,658,732,800.00</b>	<b>2,161,313,116.95</b>
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,658,732,800.00</b>	<b>2,161,313,116.95</b>
132001	Орон нутгийн төсвөөс	<b>2,658,732,800.00</b>	<b>2,161,313,116.95</b>
4	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>		
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	01	01
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	29	29
620001	Удирдах ажилтан	07	07
620002	Гүйцэтгэх ажилтан	14	14
620003	Үйлчлэх ажилтан	03	03
620004	Гэрээт ажилтан	05	05

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>16,712,746.00</b>	<b>355,700,615.24</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>16,712,746.00</b>	<b>126,476,028.24</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	16,433,500.00	126,476,028.24
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		35,539,700.77
210101	Үндсэн цалин		14,593,839.85
210102	Нэмэгдэл		20,945,860.92
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		4,442,462.47
210201	Тэтгэврийн даатгал		3,094,339.68
210202	Тэтгэмжийн даатгал		335,947.00
210203	ҮОМШӨ-ний даатгал		273,092.40
210204	Ажилгүйдлийн даатгал		67,189.40
210205	Эрүүл мэндийн даатгал		671,893.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	2,400,000.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	2,400,000.00	00.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,867,840.00	1,122,875.00
210401	Бичиг хэрэг	203,754.00	1,122,875.00
210402	Тээвэр, шатахуун	1,664,086.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,892,900.00	20,000,000.00
210604	Урсгал засвар	6,892,900.00	20,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	00.00	9,507,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	9,507,700.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,272,760.00	55,863,290.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,272,760.00	55,863,290.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	279,246.00	0.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	279,246.00	00.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	00.00	<b>229,224,587.00</b>
2200	Догоод эх үүсвэрээр	00.00	229,224,587.00
220001	Барилга байгууламж	00.00	200,000,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	29,224,587.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	16,712,746.00	355,700,615.24
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	16,712,746.00	355,700,615.24
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,264,086.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,272,760.00	269,947,058.24
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,175,900.00	85,753,557.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газрын тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газар нь сумын Засаг даргатай 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 45 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас 41 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, тодорхой үр дүнд хүрсэн хэрэгжих шатандаа байгаа 4 арга хэмжээ, хэрэгжилт 99,0 %-тай дүгнэгдсэн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн А/17 тоот захирамжаар байгууллагын бүтэц, орон тоог улс төрийн албан хаагч 6, төрийн захиргааны 10, төрийн үйлчилгээний 7, гэрээт 6, нийт 29 албан хаагчийг баталж, үйл ажиллагаагаа 27 албан хаагчтайгаар явуулсан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Засгийн газрын болон аймаг, сумын Засаг даргын мөрийн хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж сумын үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг сайжруулж, үйлчилгээний чанар, тэгш хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуралдааны 01 тогтоолоор сумын 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө баталсны дагуу ойн арга хэмжээг 2023 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс 23-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн байна.

Олон улсын чанарын удирдлагын менежментийн тогтолцоо ISO 9001:2015 стандартыг төрийн албанд хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагын хүрээнд 2023 онд Заамар сумын Засаг даргын Тамгын газарт нэвтрүүлэх ажлыг Менежмент ба ур чадвар хүрээлэнтэй гэрээ байгуулан 4 удаагийн сургалт зохион байгуулж ажилласан байна.

Засаг даргын Тамгын газрын хурлын танхимын засварын ажилд 11,316.9 мянган төгрөг, хоёр давхрын шал солих ажилд 14,700.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж, иргэд, албан хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулан ажилласан байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2013 онд аймгийн хэмжээнд батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 23-ны 2/24 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4,004,444.4 мянган төгрөгөөр буюу 2 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	10,830.4	63,501.7	52,671.3
Бараа материал	154,234.4	284,268.0	130,033.6
Үндсэн хөрөнгө	3,730,776.0	7,552,515.5	3,821,739.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,895,840.8</b>	<b>7,900,285.2</b>	<b>4,004,444.4</b>
Өр төлбөр	0.0	60.4	60.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,895,840.8	7,900,224.8	4,004,384.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>3,895,840.8</b>	<b>7,900,285.2</b>	<b>4,004,444.4</b>

Дээрх хүснэгтээс харахад:

Авлагын дансны оны эхний үлдэгдэл 10,830.4 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 63,501.7 мянган төгрөг болж, 52,671.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл 34,277.0 мянган төгрөг, 4 дүгээр багт спорт чийрэгжүүлэлтийн танхимын эхний 50 хувийн санхүүжилтийн 29,224.4 мянган төгрөгийг байгууллагаас авах авлагаар бүртгэж, нийт 63,501.5 мянган төгрөгийн авлага шинээр үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 284,268.0 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 130,033.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Энэ нь сумын 100 жилийн үйл ажиллагаатай холбогдуулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас хандиваар авсан гэрийн цагаан бүрээс, цаваг, өрх, бүслүүр болон бөхийн зодог шуудаг, жанжин малгай, засуулын дээл, малгай, хантааз, бөхийн асар, ууцны цар, таваг, ширээ зэрэг 24,460.0 мянган төгрөгийн аж ахуйн материалыг Заамарын ирээдүй холбоо ГҮТББ-аар дамжуулан үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн байна.

Мөн Заамарын хөгжил ОНӨААТҮГ-аас 16,000.0 мянган төгрөгийн ногоон тэжээл, Монголросцветмет ХХК-аас нийгмийн хариуцлагын гэрээний хүрээнд 8,568.0 мянган төгрөгийн хорголжин тэжээл, нийт 24,568.0 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг үнэ төлбөргүй хүлээж авсан байна.

Малын үүлдэр угсаа сайжруулах зорилгоор сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4 бух 20,000.0 мянган төгрөгөөр бэлтгэж, мал амьтад дансанд бүртгэсэн байна.

Төсвийн хөрөнгөөр цэнгэлдэх хүрээлэнгийн зураг төсөв 20,250.0 мянган төгрөгөөр, Төмстий багт цахилгааны шугам татах ажлын зураг төсөв 34,867.6 мянган төгрөгөөр бэлтгэж, аж ахуйн материалд бүртгэсэн байна.

Эдгээр нь бараа материалын дансны үлдэгдлийн 130,033.6 мянган төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7,552,515.5 мянган төгрөг болж, 3,821,739.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Төсвийн хөрөнгөөр худалдан авсан 601,592.0 мянган төгрөгийн, үнэ төлбөргүй хандив тусламжаар 3,497,601.2 мянган төгрөгийн, нийт 4,163,262.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 14-ний А/48 тоот тушаалаар орлогод авсан байна. Үүнд:

1. Шилжих үлдэгдлээс санхүүжүүлсэн хөрөнгийн зардлаас:

- Цэнгэлдэх хүрээлэн 292,004.5 мянган төгрөгөөр, гэрэлт гудамж 231,700.2 мянган төгрөгөөр, байгууллагын гадна төмөр хашаа 11,811.9 мянган төгрөгөөр, хос ширээ, төмөр шүүгээ, сандал гэх мэт 4 тавилга эд хогшилыг 3,438.0 мянган төгрөгөөр, суурин болон зөөврийн компьютер, харуул хамгаалалтын камер, принтер зэрэг тоног төхөөрөмжийг 10,317.0 мянган төгрөгөөр, санхүүгийн программ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 цахим программыг 6,500.0 мянган төгрөгөөр, барилгын сайжруулалт 45,820.5 мянган төгрөгөөр, нийт 601,592.0 мянган төгрөгөөр хөрөнгө худалдан авсан байна.

2. Үнэ төлбөргүй хүлээж авсан хөрөнгүүд:

- Шижир алтны хүүхдийн цэцэрлэгийн барилга болон уурын зуухны барилгыг 64,068.8 мянган төгрөгөөр балансаас баланст.
- Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр багуудад 3 худаг 71,615.0 мянган төгрөгөөр, Цэвэрлэх байгууламжийн шинэ барилга 621,293.1 мянган төгрөгөөр, 2 худгийн цахим төхөөрөмж 34,000.0 мянган төгрөгөөр, цэнгэлдэх хүрээлэнгийн автозогсоол 298,802.7 мянган төгрөгөөр, 9,8 км цахилгаан дамжуулах 501,113.7 мянган төгрөгөөр
- Сумын 100 жилийн ойн хандиваар зөөврийн компьютер, цахилгаан мотор, телевизор зэрэг 13,200.0 мянган төгрөгөөр, цомцог гэр 22,200.0 мянган төгрөгөөр

- Нийгмийн хариуцлагын гэрээгээр Хос богд ХХК-иас Хайлааст багийн чийрэгжүүлэлтийн барилга 110,000.0 мянган төгрөгөөр, Заамар нутгийн хөгжлийг дэмжих сангаас цэцэрлэгт хүрээлэнгийн кофе шопын барилга болон цэцэрлэгт хүрээлэнгийн ариун цэврийн байгууламж 106,589.4 мянган төгрөгөөр, Илт гоулд ХХК-иас 4 багийн Засаг дарга нарт 4 суудлын автомашин 80,000.0 мянган төгрөгөөр, Эм Жи Жи И Си ХХК-иас усны машин 38,500.0 мянган төгрөгөөр, Галтбадрах ХХК-иас сурын холбоонд сүүдрэвч 2,000.0 мянган төгрөгөөр, Уулс Заамар ХХК-иас машины зогсоолын 1 дүгээр хэсгийг 222,000.0 мянган төгрөгөөр, Юбиксолюшин ХХК-иас морин тойруулгын тоглоом, элсний волейболын талбайг 63,800.0 мянган төгрөгөөр, Ирмүүн босго ХХК-с 2 сүүдрэвч 38,000.0 мянган төгрөгөөр, Голден хаймер ХХК-иас сагсны талбай 45,000.0 мянган төгрөгөөр, Цүй Ханг Инвест ХХК-иас гольфын талбай 70,000.0 мянган төгрөгөөр, Монгол майнинг ХХК-иас хөл бөмбөгийн талбай, Баянгол эко Заамар ХХК-иас өвлийн хүлэмж 215,500.0 мянган төгрөгөөр, нийт 3,497,601.3 мянган төгрөгөөр орлогод авсан нь нөлөөлсөн байна.

Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 04 тоот тогтоолыг үндэслэн машин тоног төхөөрөмжийн данснаас 17,448.3 мянган төгрөгийн, авто тээврийн хэрэгсэл данснаас 16,700.0 мянган төгрөгийн, тавилга эд хогшил данснаас 4,914.0 мянган төгрөгийн, бусад үндсэн хөрөнгө данснаас 27,726.1 мянган төгрөгийн, нийт 66,788.5 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгалын комиссоор устгал хийлгэж, данснаас хассан байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 341,522.7 мянган төгрөг байна.

Өглөгийн дансанд оны эцэст 2 албан хаагчийн шагналаас хувь хүний орлогын албан татварын суутгалыг суутгаад татварын албанд шилжүүлээгүй 60.4 мянган төгрөгөөр өглөг үүсгэсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,900,224.9 мянган төгрөг болж 4,004,384.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 567,488.4 мянган төгрөг, нийт зарлагыг 567,488.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийг 1,605,649.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 2,173,137.8 мянган төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 920,956.1 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 684,693.3 мянган төгрөгөөр баталсан байна.

Энэ нь хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 1,375,873.6 мянган төгрөг, урсгал зардалд 125,189.1 мянган төгрөг, байр ашиглалтын тогтмол зардал 84,086.7 мянган төгрөг, хур хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах арга хэмжээнд 20,500.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Сумын ИТХ-ын 2023 оны 9 дүгээр сарын 07-ны өдрийн 02 дугаар тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 2,173,137.8 мянган төгрөгийг 485,595.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2,658,732.8 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэсэн

2 хөтөлбөрийн 8 арга хэмжээний 1,465,141.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,193,591.4 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 497,419.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,161,313.1 мянган төгрөг буюу 81,3 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалин, нийгмийн даатгалын зардлаас 11,401.3 мянган төгрөг, албан томилолтын зардлаас 6,269.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 1,565.3 мянган төгрөг, хөрөнгийн зардлаас 464,070.7 мянган төгрөг, нийт 497,419.7 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	575,129.0	551,536.4	23,592.6	95.9%
2	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80103- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	69,835.9	69,835.9	0.0	100.0 %
3	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80106- Баг, хорооны үйл ажиллагааны зардал	110,712.6	101,426.6	9,286.0	91.6%
4	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	19,000.0	18,939.6	60.4	99.7%
5	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 80918-Бусад	1,837,495.3	1,373,424.6	464,070.7	74.7%
6	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 81102- Орон нутгийн нөөц хөрөнгө	21,060.0	20,649.8	410.2	98.1%
7	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага 82801- Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0.0	100%
8	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага 82212- Хур хог хаягдал, орчны бохирдол	20,500.0	20,500.0	0.0	100.0 %
	<b>Дүн</b>	<b>2,658,732.8</b>	<b>2,161,313.1</b>	<b>497,419.7</b>	<b>81.3%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажлын санхүүжилт 200,000.0 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах санхүүжилт 58,449.2 мянган төгрөг, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд зориулан 44,403.2 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/489 тоот захирамжаар гамшгийн

эрсдэлийн дэмжлэгт 5,000.0 мянган төгрөг, статистикийн хэлтсээс малын тооллого хийхэд зориулан 1,248.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоор өмнөх оны нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн орлого 10,830.4 мянган төгрөг, өвс тэжээл борлуулсан орлого 13,855.7 мянган төгрөг, Монголросцветмет Төрийн өмчит үйлдвэрийн газраас хандив 60,000.0 мянган төгрөг, тендерийн бичиг баримтын 1,067.5 мянган төгрөг, нийт 394,854.4 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөлийн ажилд 200,000.0 мянган төгрөг, спорт чийрэгжүүлэлт, тоглоомын талбай байгуулах ажлын эхний 50 хувийн санхүүжилтэд 29,224.6 мянган төгрөг төрийн албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 39,526.5 мянган төгрөг, үнэлгээний хорооны цалинд 455.6 мянган төгрөг, гамшгийн үеийн онцгой комиссын үйл ажиллагаанд 5,000.0 мянган төгрөг, өмнөх оны нэмэлт санхүүжилтийг татан төвлөрүүлсэн актын төлбөрт 9,614.9 мянган төгрөг, шатахууны зардалд 1,807.7 мянган төгрөг, өвс тэжээлийн зардалд 7,700.0 мянган төгрөг, Монголросцветмет Төрийн өмчит үйлдвэрийн газар нийгмийн хариуцлагын гэрээний дагуу их дээд сургуульд суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт 40,000.0 мянган төгрөг, Шижир алт цэцэрлэгээс ЗДТГ-т балансаас баланст шилжүүлэн авсан барилгын сантехникийн засварын зардалд 20,000.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 2,371.4 мянган төгрөг, нийт 355,700.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Зарцуулаагүй үлдэгдэл 39,153.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт / мянган төгрөгөөр /*

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 99.0 %	2,638,232.8	2,140,813.1
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 100.0 %	20,500.0	20,500.0

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 81,3 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 100,0 хувиар хэрэгжүүлж, 2023 оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 497,419.7 мянган төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд татан төвлөрүүлсэн байна.

### **3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл**

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй 8 тендер, тендер шалгаруулалтын онцгой журмын харьцуулалтын аргаар 9 тендерийг зарлаж, шууд худалдан авах журмаар 19 тендер,

нийт 36 тендер шалгаруулалтыг зохион байгуулж, шилэн дансны цахим систем болон төрийн худалдан авах ажиллагааны цахим системд тухай бүр мэдээллийг байршуулсан байна. Үүнд:

- Эмнэлгийн фасад засварын ажил 97,649.0 мянган төгрөгөөр тендер зарлан 92,740.0 мянган төгрөгөөр Найдварт жигүүр ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Соёлын төвийн барилгын их засварын ажлыг 265,147.8 мянган төгрөгөөр тендер зарлан Танан цамхаг ХХК-тай 209,988.4 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Нэгдүгээр сургуулийн гал тогооны барилгын засварын ажил 66,052.8 мянган төгрөгөөр тендер зарлан Өндөрлөг ХХК-тай 58,784.5 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Инээмсэглэл хүүхдийн цэцэрлэгийн барилгын гадна фасад засварын ажил 83,538.5 мянган төгрөгөөр тендер зарлан Хас шонхор ХХК-тай 79,361.6 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Цэнгэлдэх хүрээлэн барих ажил 590,000.0 мянган төгрөгөөр тендер зарлан, Хажимэ констракшн ХХК-тай 584,242.6 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.
- Хайлааст багийн худгуудад цахим карт суурилуулах ажлыг тендер зарлан Ирмүүн бармат ХХК-тай гэрээ байгуулан 34,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.
- Төмстий багийг цахилгаан эрчим хүчинд холбох ажил 530,000.0 мянган төгрөгөөр тендер зарлан Чандмань хонгор ХХК-тай гэрээ байгуулан 514,514.8 мянган төгрөгөөр гүйцэтгүүлсэн байна.
- Тосон, Төмстий багт бэлчээрийн худаг гаргах 75,000.0 мянган төгрөгөөр тендер зарлан Буян ус ХХК-тай 75,000.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Ерөнхий гэрээгээр цахим дэлгүүрээс Засаг даргын Тамгын газрын тоног төхөөрөмжийг 9,850.0 мянган төгрөгөөр худалдан авалт хийсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 23-ний өдрийн 02/24 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны батлагдсан төсвийн нийт зарлага 1,523,044.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 22,845.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 17,134.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Тус байгууллага тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээнээс хэмнэгдсэн 497,419.7 мянган төгрөгийн зардлыг татан төвлөрүүлсэн байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг хэрэгжүүлэн албан ажлын 3 суудлын автомашинд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авсан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад тендер худалдан авах ажиллагааны болон цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 12 мөнгөн гүйлгээ, төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 46 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

Шилэн дансанд байршуулбал зохих 159 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 152 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 98,4 хувьтай байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж, 1 албан шаардлага, 2 зөвлөмж зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 2/113 тоотой ирүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0.0	0	0.0	0
Албан шаардлага	0	0.0	0	0.0	0
Зөвлөмж	2	26,300.0	2	26,300.0	100
Нийт дүн	2	26,300.0	2	26,300.0	100

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим санг нэвтрүүлэхээр "Ухаалаг засаглал" Нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай гэрээ хийж, 3,000.0 мянган төгрөг, нягтлан бодох бүртгэлийн программ хангамж шинэчлэхээр Си Ти Эм хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж 3,500.0 мянган төгрөг төлж, нийт 3 цахим программыг дансанд авсан байна.

Энэ 3 программын байнгын ажиллагаа, хөгжүүлэлт, ашиглалт, үр дүнгийн байдлыг дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар тодорхойлж байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 706,984.0 мянган төгрөгийн 3 алдаа<sup>1</sup>, 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, аудитын явцад 691,590.4 мянган төгрөгийн 3 алдааг залрууллаа. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд 12,155.7 мянган төгрөгийн малын ногоон тэжээлийн зээлээр борлуулсны авлагыг үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз дансанд бүртгэсэн алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.1-д "үйл ажиллагааны үр дүнгийн тайлан", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-д "орлогын дэлгэрэнгүй тайлан", 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

2. Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 536,573.4 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй, Нэмэлт санхүүжилтийн тайлан нь өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5.5-д "нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

3. Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн хөрөнгийн дансанд 142,861.3 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй тайлагнасан алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4.3-д "мөнгөн гүйлгээний тайлан", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-д "жинхэнэ хэрэгжилтийн", 8 дугаар зүйлийн 8.1.4-д "мөнгөн гүйлгээний тайлан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "иж бүрэн байх", "толилуулга" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулсан.

### 5.1 Төлбөрийн акт

1. Аймгийн засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны Б/02 тоот захирамжаар сумын засаг даргад, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 25-ны Б/01 тоот захирамжаар засаг даргын орлогч болон 4 багийн засаг дарга нарт, нийт улс төрийн 6 албан тушаалтанд орон нутгийн нэмэгдэлд 15,393.6 мянган төгрөг олгосон зөрчил байна

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.17-д "Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож болно", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-д “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, 15 дугаар зүйлийн 15.1.3-т “хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” заалт, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 -д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэж заасны дагуу шийдвэрлэв.

## **5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага өгөгдөөгүй.

## **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### **1. Бусад асуудал**

#### **1.1. Илрүүлэлт:**

Байгууллагын эзэмшилд байгаа 32 газраас 19 газар бүртгэлтэй, бусад 13 газрыг данс бүртгэлд аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Газрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Газрыг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэн /цаашид "иргэн" гэх/, аж ахуйн нэгж, байгууллага энэ хуульд заасны дагуу эзэмшиж ашиглана.”, 23 дугаар зүйлийн 23.3.9-д “газар эзэмших, ашиглах эрхийг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28.1-д заасан журмын дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлэх.”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д “иргэдэд өмчлүүлснээс бусад газар”, 72 дугаар зүйлийн 72.4.1-д “эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх зарчим” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **1.2. Өгсөн зөвлөмж:**

Байгууллагын эзэмшилд байх газрыг данс бүртгэлд бүрэн авах

### **2. Хариуцлагыг сайжруулахтай холбоотой асуудал**

#### **2.1. Илрүүлэлт:**

Байгууллагын эзэмшилд байгаа 4 багийн засаг даргын хариуцсан 4 суудлын автомашин нь ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар аваагүй зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “хариуцлагатай байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д “Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ.” гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн

тайлангийн “Эрх ба үүрэг”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

## **2.2. Өгсөн зөвлөмж:**

Төрийн байгууллагын авто тээврийн хэрэгсэлүүдэд ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар авах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## **6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ**

### **6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн үр дүнгийн тайланд 12,155.7 мянган төгрөгийн малын ногоон тэжээлийн зээлээр борлуулсны авлагыг үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз дансанд буруу бүртгэсэн алдаа байна	1	12,155.7			1	12,155.7	1	12,155.7				
Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 536,573.4 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй, Нэмэлт санхүүжилтийн тайлан нь өмнөх үеийн тоон үзүүлэлтүүдтэй зэрэгцүүлэхүйц байх зарчмыг хангаж бэлтгээгүй алдаа байна.	1	536,573.4	1	536,573.4			1	536,573.4				
Мөнгөн гүйлгээний тайланд мөнгөн хөрөнгийн дансанд 142,861.3	1	142,861.3			1	142,861.3	1	142,861.3				



Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0